



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 08 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар А/169

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189 дүгээр зүйлийн 189.12 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалт явуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба /хурандаа Х.Ариунболд/, Хорих ял эдлүүлэх алба /хурандаа С.Батсайхан/-д тус тус даалгасугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Ц.АМГАЛАНБАЯР

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
ерөнхий газрын даргын 2017
оны 08 дугаар сарын 31-ний
өдрийн А/169 дугаар
тушаалын хавсралт

ЗАН ҮЙЛЭЭ ЗАСАХ СУРГАЛТАД ХАМРАГДАХ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ АВАГДСАН ХҮНИЙ ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ СУРГАЛТ ЯВУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар шүүхийн шийтгэх тогтоолоор зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Зан үйлд нөлөөлөх сургалт нь албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, гэмт хэрэг, зөрчил давтан үйлдэхээс урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийг ойлгуулахад чиглэсэн байна.

1.3.Зан үйлд нөлөөлөх сургалт / цаашид “сургалт” гэх/-ыг энэ журамд заасны дагуу хорих анги, аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс тус тус зохион байгуулна.

1.4.Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба нь энэ зүйлийн 1.3-т заасан нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

1.5.Хорих ял эдлүүлэх алба нь сургалт явуулах талаар хорих ангийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

1.6.Энэ зүйлийн 1.3-т заасан байгууллага нь сургалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189 дүгээр зүйлийн 189.13-т заасан төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бол тухайн байгууллагатай гэрээ байгуулж, хамтран ажиллана.

Хоёр. Сургалтын зохион байгуулалт

2.1.Сургалтыг хорих анги, аймаг нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, энэ журмын 1.6-д заасан төрийн бус байгууллагын сургалтын багш /цаашид “сургалтын ажилтан” гэх/ явуулна.

2.2.Шийдвэр гүйцэтгэгч шүүхээс гүйцэтгэх хуудсыг хүлээн авсан даруйд зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан этгээд /цаашид “оролцогч” гэх/-д сургалт явуулах тухай мэдэгдлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1-д заасны дагуу тогтоосон хугацаа, хуваарийн хамт харьяа хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс /сургалтын ажилтан/-т хүргүүлнэ.

2.3.Сургалтын ажилтан нь энэ зүйлийн 2.2-т заасан сургалт явуулах хугацаа, хуваарь, мэдэгдлийг хүлээн авч, оролцогчийн талаар бүртгэл хөтлөн, түүнд зан үйлд нөлөөлөх сургалтад хамрагдах талаар танилцуулж, тэмдэглэл хөтөлнө.

2.4.Сургалтын ажилтан нь оролцогчийн хувийн байдал, үйлдсэн гэмт хэргийн шинж, шүүхээс зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авсан хугацааг харгалзан сургалтын төлөвлөгөөг боловсруулах бөгөөд хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга батална.

2.5.Сургалтын төлөвлөгөө нь дараах бүтэцтэй байна:

2.5.1.сургалтын сэдэв;

2.5.2.сургалтын цаг;

2.5.3.сургалтын үргэлжлэх хугацаа;

2.5.4.сургалт явуулах багш.

2.6.Сургалтын тухайн оролцогчийн зан үйлээ засах албадлагын арга хэмжээ авагдсан хугацаанд багтаан явуулна.

2.7.Сургалтад хамрагдах оролцогчдийн талаарх бүртгэлийг харьяа хорих анги болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс хариуцан хөтөлнө.

Гурав.Сургалтын төрөл, хугацаа

3.1.Сургалт нь дараах төрөлтэй байна:

3.1.1.ганцаарчилсан;

3.1.2.бүлгийн;

3.1.3.хосолсон.

3.2.Сургалтын 1 цагийг 60 минутаар тооцох бөгөөд үргэлжлэх хугацаа нь өдөрт 4 цагаас дээшгүй, долоо хоногт 10 цагаас доошгүй байна.

Дөрөв.Сургалтад тавигдах шаардлага

4.1.Сургалт дараах шаардлагыг хангасан байна:

4.1.1.ганцаарчилсан болон бүлгийн сургалт явуулах танхимтай байх;

4.1.2.оролцогчдын сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан байх.

4.2.Оролцогчийн хүйс, үйлдсэн гэмт хэргийн шинж байдлаас хамаарч сургалтыг ялгамжтай байдлаар зохион байгуулна.

Тав.Оролцогчийн эрх, үүрэг

5.1.Оролцогч нь дараах үүрэг хүлээнэ:

5.1.1.сургалтын журмыг дагаж мөрдөх;

5.1.2.сургалтын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандаж, сургалтад бүрэн хамрагдах;

5.1.3.сургалтын ажилтан, алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

5.1.4.сургалтын хэрэглэгдэхүүнийг зориулалтын дагуу ашиглах;

5.1.5.оролцогч дахин гэмт хэрэг, зөрчил гаргавал түүнээс үүдэн гарах үр дагавар, хор уршгийн талаар ойлголт эзэмшсэн байх;

5.1.6.сургалтаар олсон мэдлэг, үр дүнг шалгуулах.

5.2.Оролцогч нь дараах эрх эдэлнэ:

5.2.1.сургалтын үргэлжлэх хугацаа, ач холбогдлын талаар мэдээлэл авах;

5.2.2.сургалттай холбоотой ном, сэтгүүлийг авч ашиглах;

5.2.3.гадаадын иргэн, харааны болон сонсголын бэрхшээлтэй этгээдийн хүсэлтээр хэлмэрч, орчуулагчийг оролцуулах.

Зургаа.Сургалтын ажилтны эрх, үүрэг

6.1.Сургалтын ажилтан нь дараах эрхийг эдэлнэ:

6.1.1.сургалтад оролцогчдод хууль ёсны шаардлага тавих;

6.1.2.сургалтад хамрагдаж буй оролцогчийг үнэлж, дүгнэх;

6.1.3.аюулгүй байдлаа хангуулах.

6.2.Сургалтын ажилтан нь дараах үүрэг хүлээнэ:

6.2.1.сургалтыг батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;

6.2.2.сургалтад хамрагдсан оролцогчдийн үнэлгээ, сургалт явуулсан тухай тайланг тогтоосон хугацаанд холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

6.2.3.албаны болон оролцогчийн хувийн мэдээллийг бусдад задруулахгүй байж;

6.2.4.оролцогчтой хувийн харилцаа тогтоохгүй байх;

6.2.5.сургалт дууссаны дараа оролцогчоос сургалтын талаарх санал авах.

Долоо.Байгууллагын эрх, үүрэг

7.1.Хорих анги, аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь дараах эрх, үүрэг хүлээнэ:

7.1.1.сургалтын орчин бүрдүүлж, аюулгүй байдлыг хангах;

7.1.2.оролцогчдыг сургалтад бүрэн хамруулах;

7.1.3.оролцогч нь энэ журмын 5.1-д заасан үүргээ биелүүгээгүй бол холбогдох арга хэмжээг авах;

7.1.4.сургалтын талаар нэгдсэн тоо бүртгэл хөтөлж, сургалтын тайлан, мэдээг улирал бүр гаргаж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

7.1.5.сургалтын талаар гадаад, дотоод байгууллагатай харилцаж, хамтран ажиллах.

Найм.Сургалтын явц

8.1.Сургалтын ажилтан нь сургалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189 дүгээр зүйлийн 189.11-т заасан хөтөлбөрийн хүрээнд, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

8.2.Сургалтын ажилтан нь сургалтын явцад дараах үйл ажиллагааг явуулна:

8.2.1.оролцогчдын ирцийг бүртгэх;

8.2.2.сургалтын явц, цаг, сэдвийн талаар тэмдэглэж, баталгаажуулах;

8.2.3.оролцогчийн сургалтад хамрагдсан ирц, оролцоог үндэслэн цагийн тооцоог гаргах.

8.3.Сургалтын ажилтан нь тухайн оролцогчийн сургалтад хамрагдаж буй байдал, түүний оролцоо, ирцийн талаар тэмдэглэл үйлдэж, баталгаажуулан сар бүр хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид хүргүүлнэ.

Ес.Сургалтад хамруулж дууссанд тооцох

9.1.Тогтоосон хугацаанд сургалтад бүрэн хамрагдсан оролцогчыг сургалтад хамруулж дуусанд тооцно.

9.2.Сургалтын ажилтан оролцогчийг сургалтад хамрагдаж дууссан талаар хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид даруй мэдэгдэн, түүний сургалтад хамрагдсан байдал, оролцоо, ирц, үнэлгээний талаарх тодорхойлолтыг ажлын 3 хоногийн дотор харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст хүргүүлнэ.

Арав.Хүлээлгэх хариуцлага

10.1.Сургалтыг хэрэгжүүлэх буй алба хаагч энэхүү журмыг зөрчсөн бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

10.2.Оролцогч энэ журмын 2.3-д заасан хугацаа, хуваарийг зөрчсөн тохиолдолд сургалтын ажилтан хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид даруй мэдэгдэж,

шийдвэр гүйцэтгэгч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189 дүгээр зүйлийн 189.9-д заасны дагуу шийдвэрлүүлнэ.

10.3.Энэ журмын 1.6-д заасан байгууллага, албан тушаалтан гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцална.

Арван нэг.Бусад

11.1.Сургалт явуулах зардлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 299 дүгээр зүйлийн 299.5-д заасны дагуу санхүүжүүлнэ. Сургалтыг төрийн бус байгууллагын санхүүжилтээр явуулж болно.

11.2.Оролцогч сургалтын хэрэглэгдэхүүнийг эвдэж гэмтээсэн, хувийн ажиллагааг алдагдуулсан тохиолдолд нөхөн төлүүлнэ.

---oOo---